



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 1/1081

Мандалговь

Элсэлтийн ерөнхий шалгалт өгөх
сурагчдад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5(а), Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 139 дүгээр тогтоолын 1.1; 1.3 дах заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 17 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дэлхийд цар тахлын хэмжээнд хүрсэн шинэ коронавирусын халдварын (COVID-19) улмаас улс оронд үүссэн хорио цээрийн дэглэмийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээл цахим хэлбэрээр явагдаж байгаатай холбогдуулан 2019-2020 оны хичээлийн жилд 12 дугаар анги төгсөж буй нийт 411 сурагчдад цахимаар хичээлээ судлан, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх боломж нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. 2019-2020 оны хичээлийн жилд 12 дугаар анги төгсөж буй нийт 411 сурагчдын "Багшийн туслах 800" цахим боловсролын цогц хичээлийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

Гурав. "Багшийн туслах" ХХК-ны "Багшийн туслах 800" цахим аппликейшнийг 2 сарын эрхтэйгээр худалдан авахгэрээ байгуулан ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ж.Мөнхчулуун)-д үүрэг болгосугай.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), Боловсрол, соёл, урлагийн газар (А.Мөнхтуяа)-т тус тус үүрэг болгосугай.

Тав. "Багшийн туслах 800" цахим аппликейшнийг худалдан авах төлбөр 12.330.000 (арван хоёр сая гурван зуун гучин мянга) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Сайнцагаан сум (Р.Мөнхтогтох), Гурвансайхан сум (Л.Өлзийбат), Дэлгэрхангай сум (О.Батчулуун), Эрдэнэдалай сум (С.Мөнхбаатар)-ын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010353

04 дүгээр сарын 27-ны өдрийн 1/1 дугаар захирамжийн хавсралт

“БАГШИЙН ТУСЛАХ 800” ЦАХИМ БОЛОВСРОЛЫН ЦОГЦ
ХИЧЭЭЛИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Сумын нэр	Сургуулийн нэр	Анги	Сурагчдын тоо	Төлбөр	Нийт төлбөр
1	Сайнцагаан	ЭДЦС	12а	24	30,000	720,000
2	Сайнцагаан	ЭДЦС	12б	25	30,000	750,000
3	Сайнцагаан	ЭДЦС	12в	31	30,000	930,000
4	Сайнцагаан	ЭДЦС	12г	24	30,000	720,000
5	Сайнцагаан	ЭДЦС	12д	27	30,000	810,000
6	Сайнцагаан	ГИЦС	12а	29	30,000	870,000
7	Сайнцагаан	ГИЦС	12б	25	30,000	750,000
8	Сайнцагаан	ГИЦС	12в	24	30,000	720,000
9	Сайнцагаан	Цэгцбилиг	12а	34	30,000	1,020,000
10	Сайнцагаан	Хүмүүнлэг	12а	19	30,000	570,000
11	Сайнцагаан	Хүмүүнлэг	12б	15	30,000	450,000
12	Сайнцагаан	Мандал	12а	22	30,000	660,000
13	Сайнцагаан	Мандал	12б	20	30,000	600,000
	Сайнцагаан сумын дүн			319		9,570,000
14	Гурвансайхан	ЕБСургууль	12а	20	30,000	600,000
	Гурвансайхан сумын дүн			20		600,000
15	Дэлгэрхангай	ЕБСургууль	12а	15	30,000	450,000
16	Дэлгэрхангай	ЕБСургууль	12б	15	30,000	450,000
	Дэлгэрхангай сумын дүн			30		900,000
17	Эрдэнэдалай	ЕБСургууль	12а	19	30,000	570,000
18	Эрдэнэдалай	ЕБСургууль	12б	23	30,000	690,000
	Эрдэнэдалай сумын дүн			42	30,000	1,260,000
	Нийт			411		12,330,000